



ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2020 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот
2021 он

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу

Засгийн газрын III байр

Утас: 976-11-326414

Цахим хуудас: www.nso.mn

И-мэйл: international@nso.mn

АГУУЛГА

I. УДИРТГАЛ.....	2
II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО	3
2.1 Өрхийн сарын дундаж нийт орлого	3
2.2 Өрхийн сарын дундаж мөнгөн орлого	7
2.3 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого.....	16
III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА	19
3.1 Өрхийн сарын дундаж нийт зарлага	19
3.2 Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага.....	24
IV. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН	32
4.1 Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт	32
4.2 Ажил эрхлэлт ба цалингийн орлого	34
V. ТЭГШ БУС БАЙДАЛ.....	35
5.1 Орлогын тэгш бус байдал	35
5.2 Зарлагын тэгш бус байдал.....	37
VI. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ.....	40
6.1 Хадгаламж.....	40
6.2 Зээл	40

I. УДИРТГАЛ

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг улирал тутам явуулах”-аар заасны дагуу судалгааг тогтмол зохион байгуулан явуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекст ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай мэдээллийг гаргах үндсэн зорилготой улс, бүс, суурьшлын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм.

Уг судалгааны 2020 оны үр дүнг нийтийн хүртээл болгох зорилгоор судалгаанд хамрагдсан 16460 өрхийн мэдээлэлд тооцоолол хийж энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.


II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

2.1 Өрхийн сарын дундаж нийт орлого

Өрхийн амьжиргаанд нөлөөлж байдаг гол хүчин зүйлийн нэг нь өрхийн орлого юм. Өрхийн нийт орлогыг өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Нэг өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 2020 онд улсын дунджаар 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 165.4 (12.3%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Өрхийн орлогын бодит өсөлтийг харахын тулд үнийн нөлөөллийг арилган тооцдог. Энэхүү тооцооллыг хийхдээ өрхийн орлогын мэдээллийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр засварлав. Тооцоогоор өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ 2020 онд 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 108.0 (9.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.1).

Зураг 2.1 Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), улсын дунджаар




Улсын дунджаар өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2020 онд 92.4 хувь болж, өмнөх оноос 0.8 нэгж хувиар, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 4.1 болж, 0.3 нэгж хувиар нэмэгдэж, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 3.5 болж өмнөх оноос 1.1 нэгж хувиар буурсан байна.

Нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2020 онд өмнөх оноос хотод 205.6 (14.4%) мянган төгрөг, хөдөөд 89.6 (7.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн орлогыг хооронд нь харьцуулбал, 2020 онд хотын нэг өрхийн сарын дундаж орлого хөдөөгийнхөөс 362.2 (28.5%) мянган төгрөгөөр илүү байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн орлогын зөрүү өмнөх оноос 116.0 мянган төгрөг буюу 7.6 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.2).

Өрхийн сарын дундаж нийт орлогын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзэхэд нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос хотод 1.1 нэгж хувиар нэмэгдэж, харин хөдөөд 0.3 нэгж хувиар буурсан байна (Зураг 2.3).

Зураг 2.2 Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), хот, хөдөөгөөр

Зураг 2.3 Нэг өрхийн сарын дундаж нийт орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), хот, хөдөөгөөр




Нэг өрхийн сарын дундаж нийт орлогыг бүсээр¹ авч үзэхэд 2020 онд өмнөх оноос Баруун бүсэд 229.4 (19.5%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 120.0 (9.4%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 80.4 (7.0%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 64.9 (5.2%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 2.4).

¹ **Баруун бүсэд** Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд; **Хангайн бүсэд** Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл; **Төвийн бүсэд** Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв; **Зүүн бүсэд** Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд хамрагдана.


Нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2020 онд Баруун бүсэд хамгийн бага буюу 84.9 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 11.6 хувь байна (Зураг 2.5).

Зураг 2.4 Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), бүсээр




Өрхийн сарын дундаж нийт орлогын бүтцийг бүсээр авч үзэхэд нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос Төвийн бүсэд 1.5 нэгж хувиар, Баруун бүсэд 0.1 нэгж хувиар буурсан бол Хангайн бүсэд 1.6 нэгж хувиар, Зүүн бүсэд 1.1 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.5).

Зураг 2.5 Нэг өрхийн сарын дундаж нийт орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), бүсээр




Нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 229.2 (15.2%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 153.7 (12.4%) мянган төгрөгөөр, сумын төвд 134.6 (11.7%) мянган төгрөгөөр, хөдөөд 38.9 (3.2%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 2.6).

Зураг 2.6 Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), суурьшлаар



Зураг 2.7 Нэг өрхийн сарын дундаж нийт орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), суурьшлаар




2.2 Өрхийн сарын дундаж мөнгөн орлого

Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, оны үнээр 2020 онд улсын дунджаар 1.4 сая төгрөг болж, өмнөх оноос 163.8 (13.3%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг задалвал, цалин хөлсний орлого, оны үнээр өмнөх оноос 75.6 (11.1%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 68.5 (30.2%) мянган төгрөгөөр, бусад орлого 30.8 (28.0%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 11.1 (5.2%) мянган төгрөгөөр буурсан байна.


Өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит мөнгөн орлогын хэмжээ 2020 онд 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 108.8 (10.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бодит мөнгөн орлогыг задалвал, цалин хөлсний бодит орлого өмнөх оноос 48.2 (8.7%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого 50.7 (27.3%) мянган төгрөгөөр, бусад бодит орлого 22.7 (25.2%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний бодит орлого 12.8 (7.3%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 2.8).

Зураг 2.8 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), улсын дунджаар




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2020 онд хөдөөгийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 60.1 хувийг цалин хөлсний орлого болон тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь хотын өрхийн цалин хөлсний орлогоос 0.6 нэгж хувиар бага байна (Зураг 2.10).

Зураг 2.9 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), хот, хөдөөгөөр



Зураг 2.10 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), хот, хөдөөгөөр




Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг төрлөөр нь задалж харвал, 2020 онд өмнөх оноос улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь 0.6 нэгж хувиар, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.1 нэгж хувиар, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 нэгж хувиар нэмэгдсэн байна (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь, тэтгэвэр, тэтгэмжийн төрлөөр

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	2019	2020	2019	2020	2019	2020
Өндөр насны тэтгэвэр	12.2	12.8	12.0	12.2	13.0	14.8
Хүүхдийн мөнгө	1.8	3.9	1.6	3.6	2.3	5.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	2.1	2.0	2.0	1.8	2.5	2.7
Жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	0.7	1.1	0.6	1.0	0.7	1.0
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.4	0.3	0.4	0.2	0.5	0.3
Бусад тэтгэвэр, тэтгэмж	1.2	1.1	1.1	1.1	1.2	1.0


Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг бүсээр авч үзэхэд 2020 онд өмнөх оноос Баруун бүсэд 194.0 (19.4%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 119.3 (10.8%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 90.1 (8.9%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 39.3 (3.5%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 2.11).

Зураг 2.11 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), бүсээр



Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг бүсээр авч үзэхэд мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос бүсүүдэд 0.1-3.2 нэгж хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 2.2-4.7 нэгж хувиар нэмэгдсэн бол өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 3.9-7.4 нэгж хувиар буурсан байна (Зураг 2.12).

Зураг 2.12 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), бүсээр




Өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 240.5 (16.7%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 153.7 (13.2%) мянган төгрөгөөр, сумын төвд 107.9 (10.6%) мянган төгрөгөөр, хөдөөд 27.2 (2.9%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 2.13).

Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг суурьшлаар авч үзэхэд мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хот болон аймгийн төвд 0.7-3.5 нэгж хувиар буурсан бол сумын төв, хөдөөд 0.6-2.5 нэгж хувиар нэмэгдсэн байна. Тэтгэвэр, тэтгэмжийн орлогын мөнгөн орлогод эзлэх хувь Улаанбаатар хотод 1.9 нэгж хувиар, аймгийн төвд 2.9 нэгж хувиар, сумын төвд 3.5 нэгж хувиар, хөдөөд 5.9 нэгж хувиар тус тус өмнөх оноос нэмэгдсэн бол өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь Улаанбаатар хотод 0.3 нэгж хувиар, аймгийн төвд 3.4 нэгж хувиар, сумын төвд 3.0 нэгж хувиар, хөдөөд 8.6 нэгж хувиар тус тус өмнөх оноос буурсан байна.

Хөдөөгийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 55.8 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого бүрдүүлж байхад бусад суурьшилд 51.3-62.7 хувийг цалин хөлсний орлого бүрдүүлж байна (Зураг 2.14).

Зураг 2.13 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), суурьшлаар




Зураг 2.14 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), суурьшлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг сууцны төрлөөр задлан харвал, 2020 онд улсын дунджаар орон сууцанд амьдардаг өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх оноос 250.3 (14.6%) мянган төгрөг, байшинд амьдардаг өрхүүдийнх 155.3 (13.1%) мянган төгрөг, гэрт амьдардаг өрхүүдийнх 96.3 (10.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.15).

Зураг 2.15 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), сууцны төрлөөр



Түүнчлэн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг сууцны төрлөөр задлан харвал, 2020 онд улсын дунджаар гэрт амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 40.3 хувийг цалин хөлсний орлого, 27.3 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 26.0 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 6.4 хувийг бусад орлого эзэлж байна. Харин орон сууцанд амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 62.5 хувийг цалин хөлсний орлого, 16.0 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 13.6 хувийг бусад орлого, 7.9 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого эзэлж байна. Сууцны бүх төрөлд мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь өмнөх оноос нэмэгдсэн байна (Зураг 2.16).


Зураг 2.16 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), сууцны төрлөөр



Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 500.0 мянган төгрөг хүртэлх орлоготой өрхийн эзлэх хувь 2020 онд өмнөх оноос 2.8 нэгж хувиар, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 2.9 нэгж хувиар, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 2.0 нэгж хувиар буурч, харин 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 0.2 нэгж хувиар, 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 2.1 нэгж хувиар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 3.0 нэгж хувиар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн эзлэх хувь 2.4 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзэхэд 2020 онд хотын нийт өрхийн 8.9 хувь, хөдөөгийн нийт өрхийн 25.1 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэлх орлоготой, мөн хотын 22.9 хувь, хөдөөгийн 17.5 хувь нь 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой, хотын 37.6 хувь, хөдөөгийн 18.5 хувь нь 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байна (Зураг 2.17).

Зураг 2.17 Мөнгөн орлогын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувиар




Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 26.9 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 48.0 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 17.5 хувь, бусад орлого 7.6 хувийг эзэлж байна (Зураг 2.18.3).

Мөн сард дунджаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 45.9 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 33.3 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 14.2 хувь, бусад орлого 6.6 хувийг эзэлж байна (Зураг 2.18.5).



Зураг 2.18 Мөнгөн орлогын бүлэглэлтийн бүтэц, дүнд эзлэх хувь, улсын дунджаар, 2020 он

1. 300 000 төгрөг хүртэл





2. 300 001–500 000 төгрөг

3. 500 001–700 000 төгрөг




4. 700 001–900 000 төгрөг


5. 900 001–1 100 000 төгрөг




6. 1 100 001–1 600 000 төгрөг




7. 1 600 001–2 100 000 төгрөг



8. 2 100 001–3 000 000 төгрөг



9. 3 000 001 төгрөгөөс дээш



2.3 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого

Судалгааны 2020 оны дүнгээр нийт өрхийн 12.2 хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа нь өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж буй өрхүүдийн 38.4 хувь нь худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 1.4 нэгж хувиар, бусад салбарт үйл ажиллагаа эрхэлж буй өрхүүдийн эзлэх хувь 5.9 нэгж хувиар нэмэгдсэн бол барилга, уул уурхай, зочид буудал, ресторан, аялал жуулчлал, тээвэрлэлт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа өрхүүдийн эзлэх хувь өмнөх оноос 0.3-3.2 нэгж хувиар буурсан байна (Зураг 2.19).


Зураг 2.19 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлт, үйл ажиллагааны салбараар (дүнд эзлэх хувь), улсын дунджаар



Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн хувьд нэг өрхийн сарын дундаж орлогыг үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 2020 онд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого хамгийн өндөр буюу 940.7 мянган төгрөг, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого хамгийн бага буюу 497.3 мянган төгрөг байна.


Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогын өсөлтийг үйл ажиллагааны салбараар нь өмнөх онтой харьцуулж харвал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийнх 136.2 (17.9%) мянган төгрөгөөр, барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийнх 54.9 (7.1%) мянган төгрөгөөр, тээвэрлэлтийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа өрхийнх 39.5 (7.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.20).

Зураг 2.20 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого (мянган төгрөг), үйл ажиллагааны салбараар



Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого Төвийн бүс болон Улаанбаатар хотод бусад бүс, суурьшилтай харьцуулахад хамгийн өндөр байна (Зураг 2.21).


Зураг 2.21 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого (мянган төгрөг), бүс, суурьшлаар, 2020 он




Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр ангилж үзвэл, 2020 онд өрхийн тэргүүлэгч нь 40-49 настай өрхийн сарын дундаж орлого 824.5 мянган төгрөг буюу бусад насны тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад хамгийн өндөр, өрхийн тэргүүлэгч нь 60-аас дээш настай өрхийн сарын дундаж орлого бусад насны тэргүүлэгчтэй өрхөөс бага байна. Мөн өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлого эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлогоос 63.9 (9.3%) мянган төгрөгөөр илүү байна (Зураг 2.22).

Зураг 2.22 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого (мянган төгрөг), өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, хүйсээр, 2020 он

а. Өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр



б. Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр




III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА

3.1 Өрхийн сарын дундаж нийт зарлага

Өрхийн нийт зарлагыг өрхийн мөнгөн зарлага, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 2020 онд улсын дунджаар 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 102.8 (7.3%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2020 онд 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 56.5 (4.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 3.1).

Зураг 3.1 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), улсын дунджаар




Улсын дунджаар нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2020 онд 92.5 хувь болж өмнөх оноос 0.5 нэгж хувиар, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 4.1 болж 0.4 нэгж хувиар нэмэгдсэн бол бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 3.4 болж 0.9 нэгж хувиар буурсан байна.


Өрхийн сарын дундаж нийт зарлагыг хот, хөдөөгөөр авч үзэхэд 2020 онд өмнөх оноос хотод 133.5 (9.0%) мянган төгрөгөөр, хөдөөд 44.7 (3.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн дундаж зарлагыг хооронд нь харьцуулбал, 2020 онд хотын нэг өрхийн сарын дундаж нийт зарлага хөдөөгийнхөөс 266.3 (19.8%) мянган төгрөгөөр илүү байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн зарлагын зөрүү өмнөх оноос 88.8 мянган төгрөг буюу 6.1 нэгж хувиар өссөн байна (Зураг 3.2).

Өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос хотод 1.0 нэгж хувиар өсөж, хөдөөд 0.9 нэгж хувиар буурсан байна. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.9 нэгж хувиар, хөдөөд 1.1 нэгж хувиар буурсан бол өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.1 нэгж хувиар буурч, хөдөөд 2.0 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 3.3).

Зураг 3.2 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), хот, хөдөөгөөр



Зураг 3.3 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), хот, хөдөөгөөр




Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагыг бүсээр авч үзэхэд 2020 онд өмнөх оноос Баруун бүсэд 190.1 (14.5%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 108.9 (8.0%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 34.8 (2.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн бол Төвийн бүсэд 26.7 (1.9%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.4).


Нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2020 онд Баруун бүсэд хамгийн бага буюу 85.9 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 10.8 хувь байна (Зураг 3.5).

Өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос Төвийн бүсэд 2.1 нэгж хувиар, Баруун бүсэд 0.6 нэгж хувиар буурсан бол Хангайн бүсэд 1.1 нэгж хувиар, Зүүн бүсэд 0.8 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос бүсүүдэд 0.1-1.3 нэгж хувиар буурсан бол өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 0.1-2.2 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 3.5).

Зураг 3.4 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), бүсээр




Зураг 3.5 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), бүсээр




Нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 154.8 (10.1%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 86.3 (6.3%) мянган төгрөгөөр, сумын төвд 40.3 (3.1%) мянган төгрөгөөр, хөдөөд 49.4 (3.8%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 3.6).

Зураг 3.6 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), суурьшлаар



Зураг 3.7 Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), суурьшлаар




3.2 Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага

Өрхийн мөнгөн зарлага нь хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага болон бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагаас бүрдэнэ.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, оны үнээр 2020 онд улсын дунджаар 1.4 сая төгрөг болж, өмнөх оноос 101.2 (7.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг задалбал, хүнсний зүйлийн зарлага, оны үнээр өмнөх оноос 27.1 (9.9%) мянган төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 74.4 (7.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн бол бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлага 0.3 (1.0%) мянган төгрөгөөр буурсан байна.

Мөн өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит мөнгөн зарлагын хэмжээ 2020 онд 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 57.3 (5.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бодит мөнгөн зарлагыг задалвал, хүнсний зүйлийн бодит зарлага өмнөх оноос 16.8 (7.5%) мянган төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 41.3 (5.0%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин бусдад өгсөн бэлэг, тусламжийн бодит зарлага 0.8 (3.4%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.8).

Зураг 3.8 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага (мянган төгрөг), улсын дунджаар



Улсын дунджаар 2020 онд өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлагын 32.8 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 24.2 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.3 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 7.7 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал, 4.3 хувийг элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан, 3.9 хувийг цэвэр ус, ундаа, жимсний шүүс эзэлж байна (Зураг 3.9).

Зураг 3.9 Нэг өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, улсын дунджаар, 2020 он




Өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 10.4 хувийг бэлэн хувцас, гутал, 8.4 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 4.9 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 4.6 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ, 4.2 хувийг боловсролын үйлчилгээний зарлага эзэлж байна (Зураг 3.10).

Зураг 3.10 Нэг өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, улсын дунджаар, 2020 он




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2020 онд хотын өрх сарын дундаж мөнгөн зарлагынхаа 75.2 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 23.2 хувийг хүнсний зүйлд зарцуулж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд хүнсний бус бараа, үйлчилгээнд 79.9 хувийг, хүнсний зүйлд 17.1 хувийг зарцуулж байна (Зураг 3.12).

Зураг 3.11 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага (мянган төгрөг), хот, хөдөөгөөр




Зураг 3.12 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), хот, хөдөөгөөр




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг бүсээр авч үзвэл, 2020 онд өмнөх оноос Баруун бүсэд 154.7 (13.7%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 108.2 (9.1%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 44.5 (4.0%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин Төвийн бүсэд 52.3 (4.1%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.13).

Зураг 3.13 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага (мянган төгрөг), бүсээр




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос Зүүн бүсэд 1.2 нэгж хувиар буурч, бусад бүсүүдэд 0.2-2.3 нэгж хувиар нэмэгдсэн бол хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь өмнөх оноос Зүүн бүсэд 0.5 нэгж хувиар нэмэгдэж, бусад бүсүүдэд 0.3-1.5 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.14).

Зураг 3.14 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), бүсээр



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 166.1 (11.4%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 86.3 (6.6%) мянган төгрөгөөр, сумын төвд 13.6 (1.2%) мянган төгрөгөөр, хөдөөд 37.7 (3.7%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 3.15).

Зураг 3.15 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага (мянган төгрөг), суурьшлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг суурьшлаар авч үзэхэд мөнгөн зарлагад хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 2020 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 0.3 нэгж хувиар буурч, бусад суурьшилд 0.5-1.4 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын мөнгөн зарлагад эзлэх хувь Улаанбаатар хотод өмнөх оноос 0.4 нэгж хувиар нэмэгдэж, бусад суурьшилд 0.1-1.0 нэгж хувиар буурсан байна. Бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын мөнгөн зарлагад эзлэх хувь бүх суурьшилд өмнөх оноос буурсан байна (Зураг 3.16).

Зураг 3.16 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), суурьшлаар



Өрхийн амьдарч буй сууцны төрөл нь өрхийн хэрэглээний зардалд хэрхэн нөлөөлж буйг харуулахаар цахилгаан, түлш, сууцны төлбөр, тээврийн үйлчилгээ (хувийн зориулалттай тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар ороогүй), харилцаа холбооны зардлыг авч үзлээ. Харилцаа холбоо болон тээврийн үйлчилгээний зардал орон сууцанд амьдардаг өрхийн хувьд хамгийн их, гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага байна. Түлшний зардал байшинд амьдардаг өрхийн хувьд хамгийн өндөр, цахилгааны зардал гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага байна. Улсын дунджаар 2020 онд нэг өрх сард дунджаар цахилгааны зардалд 25.9 мянган төгрөг, түлшинд 26.0 мянган төгрөг, сууцны төлбөрт 30.4 мянган төгрөг, тээврийн үйлчилгээнд 20.7 мянган төгрөг, харилцаа холбоонд 52.4 мянган төгрөгийг зарцуулж байна (Зураг 3.17).

Зураг 3.17 Өрхийн зарим хэрэглээний зардал (мянган төгрөг), сууцны төрлөөр, 2020 он




Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 500.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрхийн эзлэх хувь 2020 онд өмнөх оноос 0.8 нэгж хувиар, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 2.8 нэгж хувиар, 700.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурч, харин 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 1.0 нэгж хувиар, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 0.7 нэгж хувиар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 0.7 нэгж хувиар, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхийн эзлэх хувь 1.8 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзэхэд 2020 онд хотын нийт өрхийн 7.5 хувь, хөдөөгийн нийт өрхийн 21.0 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай, мөн хотын 23.7 хувь, хөдөөгийн 19.3 хувь нь 1.1-1.6

сая төгрөгийн зарлагатай, хотын 36.4 хувь, хөдөөгийн 20.7 хувь нь 1.6 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхүүд байна (Зураг 3.18).

Зураг 3.18 Мөнгөн зарлагын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувиар




Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 31.9 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 66.3 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.8 хувийг эзэлж байна (Зураг 3.19.3).

Мөн сард дунджаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 28.1 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 70.0 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.9 хувийг эзэлж байна (Зураг 3.19.5).


Зураг 3.19 Мөнгөн зарлагын бүлэглэлтийн бүтэц (дүнд эзлэх хувь), улсын дунджаар, 2020 он




1. 300 000 төгрөг хүртэл




2. 300 001–500 000 төгрөг




3. 500 001–700 000 төгрөг




4. 700 001–900 000 төгрөг




5. 900 001–1 100 000 төгрөг




6. 1 100 001–1 600 000 төгрөг




7. 1 600 001–2 100 000 төгрөг



8. 2 100 001–3 000 000 төгрөг



9. 3 000 001 төгрөгөөс дээш




IV. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН

4.1 Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлын талаарх үзүүлэлт юм. Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал өрхийн орлогод хэрхэн нөлөөлж буйг Зураг 4.1-д харууллаа. Өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2020 онд 1.6 сая төгрөг байгаа нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхөөс 502.9 (46.6%) мянган төгрөгөөр, өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур байдаг өрхөөс 512.9 (48.0%) мянган төгрөгөөр их байна. Харин өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх оноос 223.2 (16.4%) мянган төгрөгөөр нэмэгджээ.


Зураг 4.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар



Судалгааны 2020 оны дүнгээр өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 60.8 хувь нь цалин хөлсний орлого, 18.1 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 11.9 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 9.2 хувь нь бусад орлогоос бүрдэж байна (Зураг 4.2).

Өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур бол тухайн өрхийн орлогын бараг хоёрны нэгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна.

Зураг 4.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар



4.2 Ажил эрхлэлт ба цалингийн орлого

Улсын дунджаар 2020 онд нэг өрхийн сарын дундаж цалингийн орлого 754.5 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 75.6 (11.1%) мянган төгрөгөөр нэмэгджээ (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1 Өрхийн сарын дундаж цалингийн орлого (төгрөг), өрхийн тэргүүлэгчийн ажил эрхэлдэг салбараар


	Өрхийн сарын дундаж цалингийн орлого		Өрхийн сарын дундаж цалингийн орлогын голч	
	2019	2020	2019	2020
Улсын дундаж	678 901	754 492	450 000	500 000
Ажилтай: Нийт	842 036	961 806	680 000	800 000
Хөдөө аж ахуй	135 681	153 629	0	0
Аж үйлдвэр	1 230 539	1 431 393	1 040 000	1 220 000
Үйлчилгээ	974 925	1 098 920	800 000	980 000

Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж цалингийн орлого 2020 онд 961.8 мянган төгрөг байна. Ажил эрхэлдэг салбараар нь авч үзвэл, өрхийн тэргүүлэгч нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа өрхийн цалингийн дундаж орлогын хэмжээ хамгийн бага, харин аж үйлдвэрийн салбарт ажилладаг өрхийн тэргүүнтэй өрхийн цалингийн дундаж орлогын хэмжээ хамгийн өндөр байна.

Өрхийн сарын дундаж цалингийн орлогын голч хэмжээ дундаж хэмжээтэйгээ харьцуулахад 153.6-254.5 мянган төгрөгөөр бага байгаа нь өрхийн цалингийн орлогын тархалт жигд биш буюу өндөр цалинтай хүн цөөн, бага цалинтай хүн олон байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл 2020 оны байдлаар нийт өрхийн 50 хувь нь 500.0 мянган төгрөгөөс бага цалингийн орлоготой, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн тал хувь нь 800.0 мянган төгрөгөөс доош цалингийн орлоготой байна.

Цалингийн орлогын дундаж хэмжээг зөвхөн ажил эрхэлдэг хүн амаар шинжилсэнийг Зураг 4.3-т харуулав.

Зураг 4.3 Ажил эрхэлдэг хүн амын цалингийн орлогын дундаж хэмжээ (мянган төгрөг), ажил эрхэлдэг салбараар



Ажил эрхэлдэг нэг хүнд ногдох цалингийн дундаж орлогын хэмжээ 2020 онд улсын дунджаар 567.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 72.3 (14.6%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Салбараар нь авч үзвэл, аж үйлдвэрийн салбарт ажил эрхэлдэг хүний цалингийн дундаж орлогын хэмжээ өмнөх оноос 17.9 хувиар, хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлдэг хүний цалингийн орлого 13.6 хувиар, үйлчилгээний салбарт ажил эрхэлдэг хүний цалингийн дундаж орлого 12.1 хувиар нэмэгдсэн байна.


V. ТЭГШ БУС БАЙДАЛ

5.1 Орлогын тэгш бус байдал

Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр хувааж үзвэл, хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн дундаж мөнгөн орлого улсын дундаж мөнгөн орлогоос 3.3 дахин бага, хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн дундаж мөнгөн орлого 2.1 дахин их байна. Хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлого хамгийн бага орлоготой бүлгийнхээс 6.9 дахин их байна.

Өрхийн орлого нэмэгдэх тусам орлого өндөртэй бүлгүүдийн хувьд цалингийн орлогын эзлэх хувь өсөж байна. Тодруулбал улсын дунджаар хамгийн их орлоготой бүлэг хамгийн бага орлоготой бүлгийнхээс 17.2 дахин өндөр цалингийн орлоготой байгаа нь өмнөх оноос 5.4 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 5.1).

Зураг 5.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (мянган төгрөг), өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр



Хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын тал хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байхад хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн хувьд тэдний сарын дундаж мөнгөн орлогын дөнгөж аравны нэгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс харахад бага орлоготой өрхүүдийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн орлогын үзүүлэх нөлөө их байдаг нь харагдаж байна (Зураг 5.2).


Зураг 5.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь), өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр



5.2 Зарлагын тэгш бус байдал


Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр авч үзэхэд хамгийн бага зарлагатай 20 хувийн өрхүүдийн дундаж мөнгөн зарлага улсын дунджаас 3.1 дахин бага, хамгийн их зарлагатай 20 хувийнхны дундаж мөнгөн зарлага 2.1 дахин их байна. Хамгийн их зарлагатай бүлгийн сарын дундаж мөнгөн зарлага хамгийн бага зарлагатай бүлгийнхээс 6.6 дахин их байна (Зураг 5.3).

Зураг 5.3 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага (мянган төгрөг), өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр авч үзэхэд 2020 онд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүд сарын дундаж мөнгөн зарлагынхаа гуравны нэгийг хүнсний зүйлд зарцуулж байхад хамгийн их зарлагатай бүлгийн өрхүүд сарын дундаж мөнгөн зарлагынхаа тавны нэг хүрэхгүй хувийг хүнсний зүйлдээ зарцуулж байна (Зураг 5.4).

Зураг 5.4 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь), өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр



Өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлагыг задалж, зарим нэр төрлийг авч үзэхэд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүдийн хүнсний зарлагын 63.3 хувийг мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүд мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүнд хүнсний нийт зарлагынхаа 51.8 хувийг зарцуулж буй боловч мөнгөн дүнгээрээ хамгийн бага зарлагатай бүлгийнхээс дунджаар 2.6 дахин их мөнгө зарцуулж байна (Зураг 5.5).

Мөн өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагыг задалж, зарим нэр төрлийг авч үзэхэд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүд хувцас худалдан авахад хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагынхаа 10.3 хувийг зарцуулж байгаа боловч мөнгөн дүнгээр авч үзвэл хамгийн зарлага өндөртэй бүлгийнхээс 4.2 дахин бага байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүдийн эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний дундаж зарлага хамгийн бага зарлагатай бүлгийнхээс 3.8 дахин их, тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээний дундаж зарлага 9.4 дахин их боловч хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагад эзлэх хувийн жин нь 1.0 нэгж хувиар л илүү байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүд түлшиндээ хамгийн бага зарлагатай бүлгийнхтэй ойролцоо зарлага гаргадаг боловч нийт хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагад эзлэх хувийн жин нь хамгийн бага зарлагатай бүлгийнх 6.3 нэгж хувиар илүү байна (Зураг 5.6).

Зураг 5.5 Өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, хамгийн бага болон хамгийн их зарлагатай бүлгээр, 2020 он



Зураг 5.6 Өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, хамгийн бага болон хамгийн их зарлагатай бүлгээр, 2020 он



VI. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

6.1 Хадгаламж

Өрхийн санхүүгийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь хуримтлал билээ. Өрхийн орлого нь зарлагаа давж байвал хүмүүс хуримтлуулдаг, харин өдөр тутмын хэрэгцээнд дөнгөж хүрэлцэх төдий орлоготой бол хадгаламж үүсгэх боломжгүй байдаг. Судалгааны 2020 оны дүнгээр улсын хэмжээнд нийт өрхийн 31.9 хувь нь хадгаламжтай байгаа нь өмнөх оноос 6.5 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Зураг 6.1 Хадгаламжтай өрхийн эзлэх хувь




Хадгаламжтай өрхийн эзлэх хувь 2020 онд хөдөөд хотынхоос 1.0 нэгж хувиар илүү байна. Хот, хөдөөд аль алинд нь (хотод 6.8 нэгж хувь, хөдөөд 5.9 нэгж хувь) хадгаламжтай өрхийн эзлэх хувь өмнөх оноос нэмэгджээ.

6.2 Зээл

Өрхүүд санхүүгийн хэрэгцээгээ хангахын тулд албан болон албан бус эх үүсвэрээс зээл авч байна. Судалгааны 2020 оны дүнгээр улсын хэмжээнд нийт өрхийн 59.4 хувь нь ямар нэгэн² зээлтэй амьдарч байгаа нь өмнөх оноос 0.7 нэгж хувиар нэмэгджээ. Нийт зээлтэй өрхийг зээлийн төрлөөр нь авч үзэхэд 45.4 хувь нь цалингийн зээлтэй, 15.5 хувь нь тэтгэврийн зээлтэй, 14.1 хувь нь орон сууцны зээлтэй, 9.1 хувь нь хэрэглээний зээлтэй, 7.3 хувь нь автомашины зээлтэй байна (Зураг 6.2).

² Өрхийг хэдэн төрлийн зээлтэй байхаас нь үл хамааруулан ямар нэгэн зээлтэй бол тухайн өрхийг зээлтэй өрх гэж тооцсон.


Зураг 6.2 Зээлтэй өрх, зээлийн төрлөөр, улсын дунджаар



Нэг өрх хэд хэдэн зээлтэй байх тохиолдол нэлээдгүй байна. Тухайлбал, тухайн өрхөд ажил хийдэг хоёр хүн хоёулаа цалингийн зээлтэй байх, тэтгэврийн хоёр ахмад настан хоёулаа тэтгэврийн зээлтэй байх, эсвэл өрхийн нэг гишүүн нь цалингийн зээлтэй байхад нөгөөх нь лизингийн зээлтэй байх гэх мэт олон тохиолдлууд байна. Зээлийн давхцалыг тооцохдоо өрхөд ижил төрлийн зээл олон байгаа тохиолдолд нэг зээл болгон нэгтгэж авсан бөгөөд өөр төрлийн зээл байгаа тохиолдолд давхар зээлтэй гэж үзсэн. Дараах зурагт өрхийн 3 хүртэлх төрлийн зээлийн давхцалыг харууллаа.

Судалгааны 2020 оны дүнгээр зээлтэй өрхүүдийн 74.6 хувь нь зөвхөн нэг төрлийн зээлтэй, 20.9 хувь нь 2 төрлийн зээлтэй, 4.5 хувь нь 3 төрлийн давхар зээлтэй байна (Зураг 6.3).

Зураг 6.3 Зээлийн давхцал, хувиар



Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээг доорх зурагт харуулж байна. Зээлтэй нэг өрх 2020 онд дунджаар 7.9 сая төгрөгийн зээл авчээ. Орон сууцны зээлийн дундаж хэмжээ 38.9 сая төгрөг, бизнесийн зээлийн дундаж хэмжээ 16.5 сая төгрөг, автомашины зээлийн дундаж хэмжээ 14.8 сая төгрөг, цалингийн зээлийн дундаж хэмжээ 7.3 сая төгрөг, хэрэглээний зээлийн дундаж хэмжээ 4.8 сая төгрөг, тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 2.3 сая төгрөг байна (Зураг 6.4).

Зээлийн эргэн төлөлтийг харвал, зээлтэй нэг өрх 2020 онд сард дунджаар 609.2 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд өгч байна. Орон сууцны зээлтэй өрх уг зээлэндээ сард дунджаар 583.1 мянган төгрөг, цалингийн зээлтэй өрх 469.3 мянган төгрөг, тэтгэврийн зээлтэй өрх 310.9 мянган төгрөгийг эргэн төлсөн байна (Зураг 6.5).

Зураг 6.4 Сүүлийн 12 сарын хугацаанд авсан зээлийн дундаж хэмжээ (сая төгрөг), улсын дунджаар

Зураг 6.5 Зээлийн нэг сарын эргэн төлөлтийн дундаж хэмжээ (мянган төгрөг), улсын дунджаар



.....000.....